

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 06 сарын 12-ны
өдрийн 6867 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 06 сарын 04-ны өдөр

Дугаар А/259/А/173, А/94

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.13, Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга (цагдаагийн хурандаа Ж.Буянбат)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Мягмар), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат), Улсын ерөнхий прокурорын орлогч (төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны А/215,421 дугаар тушаалаар батлагдсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”, Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Цогцост шинжилгээ хийх журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.





ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан анагаах ухаан, биологийн холбогдолтой асуудлаар шүүх эмнэлгийн шинжилгээ (цаашид “шинжилгээ” гэх) хийх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч /цаашид “шинжээч” гэх/ нь шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.3. Шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Хүний биед шүүх эмнэлгийн шинжилгээ хийх

2.1. Хүний биед хийх шинжилгээнд Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.1.3, 33.1.4 дэх заалтад заасан шинжилгээ хамаарах бөгөөд энэ шинжилгээг хийхэд мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 41, 42 дугаар зүйлийг удирдлага болгоно.

2.2. Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох шинжилгээг Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар батлагдсан “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам”-ыг баримтлан хийнэ.

2.3. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалтад заасан шинжилгээг прокурорын байгууллагын шийдвэрээр хийнэ.

2.4. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3 дахь заалтад заасан шинжилгээг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр зөрчил, эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааны шийдвэрлэхэд нас тогтоох шаардлагатай тохиолдолд хийнэ.

2.5. Хүний нас тогтооход дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

2.5.1. цахим үнэмлэх, төрсний гэрчилгээ, гадаад паспорт, жолооны үнэмлэх;

2.5.2. Үндэсний төв архивын газрын лавлагаа;

2.5.3.нас тогтоолгож буй хүний намтарын талаар сайн мэдэх иргэний эрх зүйн бүрэн чадамжтай хоёроос доошгүй хүний тодорхойлолт, тайлбар;

2.5.4.насанд хүрээгүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сэтгэцийн өвчин, өөрчлөлтийн улмаас өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа хүнд шинжилгээ явуулахад түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн баримт бичиг.

2.6.Хүний нас тогтоох шинжилгээг хийхдээ тухайн хүний нас, физиологийн байдлаас хамаарч дараах үндсэн үзүүлэлтийг тусгах бөгөөд шинжээчийн дүгнэлт нь удиртгал, үзлэг, шинжилгээ, дүгнэлтийн хэсгээс бүрдсэн байна.

2.6.1.биеийн ерөнхий өсөлт, хөгжлийн хэмжилзүйн үзүүлэлтүүд /антропометрийн/ биеийн өндөр, жин, толгой, цээж, бүсэлхий, бугалга, шуу, бугуй, гуя, шилбэний тойргийн хэмжээ /лент метрээр/;

2.6.2.шүдлэлт, шүдний тоо, өнгө, хазалтын гадаргуугийн байдал, элэгдэл;

2.6.3.насанд хүрээгүй бол бэлгийн хоёрдогч шинж тэмдэг, суга, умдагны үсжилт, бэлгийн бойжилтын шинж, бэлгийн булчирхайн үйл ажиллагааны үзүүлэлт, сахал, биеийн үсжилт, бэлэг эрхтний байдал, насанд хүрээгүй эмэгтэй хүүхдийн аарцагийн хэмжээс, хөхний хэмжээ, биений юмны мөчлөг, ирэлт;

2.6.4.арьсны өнгө, үрчлээс, нөсөө толбо, түүний байрлал, тоо, гүний байдал;

2.6.5.ясжилтын үзүүлэлт, рентген шинжилгээгээр ясжилтын цэг ба нягтрал, сийрэгжилт.

2.7.Эрүүгийн хуулийн тусгай ангийн Арван хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй асуудалд шүүх эмнэлгийн шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.4, 42.6, 42.7, 47.2 дахь хэсгийг баримтална.

Гурав.Цогцост шүүх эмнэлгийн шинжилгээ хийх

3.1.Цогцост шинжилгээ хийхэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, 33.6, 33.7, 33.8 дахь хэсэг болон Монгол Улсын стандарт MNS7015:2023-ыг баримтална.

3.2.Гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний үхлийн шалтгаан болон цогцос нь хэдэн настай хүн байсныг тогтооход цогцост хийх гадна үзлэгийг дараах байдлаар хийнэ:

3.2.1.цогцсыг зөөвөрлөх буюу хувцсыг нь тайлахын өмнө цогцсын ерөнхий байдал, сүв тус бүрээс гарсан зүйл, биед хутга, багаж болон бусад гадны биет хатгагдсан, зоогдсон эсэхийг сайтар шалгах;

3.2.2.цогцсын нас, хүйс, урт, жин, биеийн галбир, мах мариа, эрхтний бүрэн бүтэн байдлыг тодорхойлох;

3.2.3.цогцсыг дээрээс доош, урдаас арагш чиглэлээр нэг бүрчлэн үзэж, үсний өнгө, урт, хэлбэр, хоёр нүдний зовхи, хүүхэн хараа, хамрын хэлбэр, уруул, амны салстын өнгө, шүдний бүрэн бүтэн байдал, хоёр чихний дэлбэн, хүзүү, их бие, мөчдийн байдал, өөрчлөлт, түүнчлэн ам, хамар, чихний суваг, нулимсны сүв, шээс, хошного, тус бүрээс ялгарсан зүйлийг шалгаж, өнгө шинж байдлыг нь тодорхойлон үзлэгийн тэмдэглэлд нарийвчлан тусгах;

3.2.4.цогцсын өөрчлөлт /хөрөлт, хөшилт, хүүрийн толбо, хаталт, ялзрал, хөлдөлт, түлэгдэлт, саванжилт, занданшилт, намагшилт/ үүссэн эсэхийг тодорхойлох.

3.3.Цогцост илэрсэн гэмтэл, өөрчлөлт тус бүрийг дараах байдлаар тэмдэглэлд тусгана:

3.3.1.гэмтлийн төрөл;

3.3.2.гэмтлийн байрлал /үүнийг гэмтэл биеийн аль хэсэгт байгааг босоо, хэвтээ тэнхлэгийн дагуу анатомийн нэршлээр нь тодорхойлно/-ыг тодорхойлох;

3.3.3.гэмтлийн өнгө /үүнийг арьс, салстын өнгөний хувирлаар, хэрэв үндсэн өнгө биш бол ямар туяа болохыг заах, эсхүл олон улсын өнгө тодорхойлогчийг ашиглан тодорхойлно/-ийг тогтоох;

3.3.4.гэмтлийн хэмжээ /үүнийг алслагдсан цэгүүдийн хооронд перпендикуляр огтлолоор хэмжиж /-г тодорхойлох;

3.3.5.гэмтлийн хэлбэр /үүнийг геометрийн дүрс, нийтлэг төстэй зүйлийн хэлбэрээр/-г тодорхойлох;

3.3.6.шархны төгсгөлүүдийн байрлалыг цагийн зүүний байрлалаар тодорхойлж бичих;

3.3.7.гэмтлийн гадаргуу /үүнийг барзгар, гөлгөр, овгор, хонхор, шүүдэс бохирдолт байгаа эсэхээр/-г тодорхойлох;

3.3.8.гэмтлийн зах ирмэг /үүнийг тэгш, тэгш бус, долгионтсон, шүдэлсэн, зах ирмэгт зулгаралт үүссэн, зулгаралт ямар хүчин зүйлийн улмаас үүссэн, арьс хууларсан зэрэг/-ийг тодорхойлох.

3.4.Цогцсын нас, хүйс, нас баралтын шалтгаантай холбоотой дараах зүйлийг тодорхойлж, тэмдэглэлд тусгана:

3.4.1.өвчин, эмгэгийн гадаад илрэл, хаван, тууралт, цэврүү, гүвдрүү, судас өргөссөн эсэх;

3.4.2.эмэгтэй хүний тухайд хөх, нөсөө, товчны хэлбэр, хэмжээ, гадна бэлэг эрхтэн, охин хальс, үтрээний амсар, хярзан, хошногны амсрын байдал, хошного, үтрээ, хөхнөөс ялгарсан зүйл;

3.4.3.ураг, нярайн цогцсын тухайд, жин, урт, биеийн галбир, салиа, зунгаг, толгойн хэмжээс, үс, шар үс, гуравдагч зовхи, чих, хамрын мөгөөрсний хэлбэржилт, хавирганы завсар, цээжний хэлбэр, хумсны ургалт, бэлгийн их, бага уруулын байдал, төмсөг хуйхнагт буусан эсэх,

хүйн байрлал, үрэвслийн цагариг, хүйн таслагдсан үзүүрийн байдал /усанд дүрж үзэх/, ихэсийн хэмжээ, жин, хэлтэнгийн тоо, цус хуралт, шохойжилт, төрөлхийн согог;

3.4.4.хэн болох нь тодорхойгүй цогцсын тухайд урт, жин, биеийн галбир, мах мариа, нүүрний хэлбэр, төрх, сахал, үсний байдал, мэнгэ, ургацаг, сорви, шивээс, хиймэл эрхтэн, өвчин, эмгэгийн илрэл, өмнө хийгдсэн гоо сайхны болон бие эрхтний хагалгааны сорви, ул мөр зэрэг таньж болох онцлог шинж.

3.4.5.мэс заслын шархны байрлал, хэмжээ, өнгөр, шархны ирмэг, мэс заслын утас, оёдлын тоо.

3.5.Цогцос дотор эрхтнийг шинжлэхдээ гавал, цээж, хэвлийн хөндийн эрхтнийг заавал нэг бүрчлэн шинжлэх ба тухайн шинжилгээний онцлогоос хамаарч аль ч хөндийгөөс эхлэн хийж болно.

3.6.Цогцсын цээж, хэвлийн хөндийн агууламж, гялтангийн байдал, гадны биет, эрхтнүүдийн байрлалыг тэмдэглэж, дотор эрхтнүүдийг иж бүрдлээр нь гаргаж араас нь урагш, дээрээс нь доош чиглэлээр эрхтэн бүрийг хамруулан үзлэг хийж, эрхтэн тус бүрийн дор дурдсан шинж чанарыг тусгасан тэмдэглэл хөтөлнө:

3.6.1.өнгө (үндсэн, суурь өнгө, туяарлаар ялгах);

3.6.2.хэлбэр;

3.6.3.тогтоц (хатуу, биелэг, зөөлөн, шавархаг, улбагар, хагас шингэн, хийрхэг г.м);

3.6.4.гадаргуу (толигор, барзгар, зангилаажсан, мөхлөгжсөн, жигд бус);

3.6.5.ирмэг (нимгэн, зузаан, мохоо, хурц);

3.6.6.хэмжээ (урт, өргө, зузааныг олон улсын Си системийн нэгжээр);

3.6.7.жин (олон улсын Си системийн нэгжээр);

3.6.8.цуллаг эрхтний цусан хангамж;

3.6.9.хөндийт эрхтний салст бүрхүүл болон дотор ханын байдал;

3.6.10.агууламж, гадны биет;

3.6.11.бүтэц (үе давхарга, дэлбэн, дэлбэнцэр, хэлтэн, хэлтэнцэр);

3.6.12.эмгэг өөрчлөлт;

3.6.13.гэмтэл түүний байрлал, шинж байдал;

3.6.14.яс, үе холбоос, мөчийн шинж байдал, хугарал, гэмтэл.

3.7.Цогцсын хөндийг нээмэгц дотор эрхтэний байрлал болон тухайн хөндийд шингэн, эсхүл гадны биет байгаа эсэхийг сайтар тогтооно. Шаардлагатай үед хийн, агаарын, өөхөн бөглөөдөс илрүүлэх сорил хийнэ. Дайвар хөндийг нээх болон мөчдийг шалгах шаардлага гарвал цогцсыг аль болох ар талаас нь нээж үзнэ. Бусад талаас нээж үзсэн тохиолдолд энэ тухай үндэслэл, шалтгааныг тэмдэглэлд тусгана.

3.8.Шинжээч дотор эрхтнийг нэг бүрчлэн үзэж шинжлэн, дараах байдлаар нэг бүрчлэн тэмдэглэлд тусгана:

3.8.1.гол судасны агууламж, өргөн, уян чанар, хатуурлын товрууны илрэл, гэмтэл, өөрчлөлт;

3.8.2.бөөрний дээд булчирхайн хэмжээ, давхаргын зааг, гэмтэл, өөрчлөлт;

3.8.3.бөөрний өөхөн эд болон бөөрний хэмжээ, өнгө, гадаргуу, тогтоц, цусан хангамж, тэвшинцэр, шээлүүр, давсагны байдал, шээсний өнгө, хэмжээ, гэмтэл, өөрчлөлт;

3.8.4.улаан хоолойн агууламж, салстын өнгө, судасны өргөсөл, гэмтэл, өөрчлөлт;

3.8.5.хэл, залгиур, төвөнхийн мөгөөрс, ховч ясны гэмтэл, өөрчлөлт;

3.8.6.цагаан мөгөөрсөн ба гуурсан хоолойн агууламж, салстын өнгө, цагираг мөгөөрсний байдал, гэмтэл, өөрчлөлт;

3.8.7.цээж, хэвлийн хөндийн цуллаг эрхтнийг дээрээс доош чиглэлээр үзэж шинжлэх ба эрхтэн тус бүрийн өнгө, хэлбэр, тогтоц /хатуу, биелэг, зөөлөн, улбагар/, гадаргуу /толигор, гялгар, барзгар, овон товон, жигд бус/, ирмэг /хурц, мохоо/, хэмжээ /урт, өргөн, зузаан см-ээр/, жин /гр-аар/, цусан хангамж, бүтэц, эмгэг өөрчлөлт, гэмтлийн шинж, байрлал;

3.8.8.зүрх, үнхэлцэг гадаргуу, эдгээрийн хөндий дэх агууламж, ховдлын ханын зузаан, цусан хангамж, хавхлаасын дэлгэсэн урт, хавхлагын ба хөхлөг булчингийн байдал, титэм судасны хатуурал, сүвний нарийсал, гэмтэл, өөрчлөлт;

3.8.9.ходоод, 12 нугалаа гэдэс, цөсний хүүдий, нарийн ба бүдүүн гэдэсний агууламж, салстын өнгө, атираа нугалаасын байдал, гэмтэл, өөрчлөлт;

3.8.10.голт, уушгины уг, чацархайн тунгалгийн булчирхай, судасны салаалалт;

3.8.11.багана нуруу, нугалам, хавирга, эгэм, өвчүү, аарцаг, дээд, доод мөчдийн ясны гэмтэл, өөрчлөлт;

3.8.12.толгой хуйхны дотор тал, гавлын орой, суурь яс, тархины хатуу ба зөөлөн бүрхүүл, тархины бөмбөлөг, түүний судасжилт, тархины эдийн гэмтэл, өөрчлөлт, ховдлын агууламж, шаардлагатай тохиолдолд гавлын дайвар хөндийн агууламж.

3.9.Цогцсын шинжилгээний дараа эрхтнийг цээж, хэвлийн хөндийд буцаан хийж, битүүлэн оёж цэгцэлж бүрэн бүтэн байдлыг хангах, хөндийнүүдээс шингэн гарахаас сэргийлж цогцсын хөндийнүүдэд чихээс хийж болно. Цогцсыг битүүмжлэн оёсны дараа угааж арчин хуурайшуулж, цогцос хадгалах газарт, эсхүл ар гэрт нь хүлээлгэн өгнө.

3.10.Цогцост хийсэн шинжилгээний дараа цогцсыг цэгцлэх, хадгалах, хүлээлгэн өгөхөд Эрүүл мэндийн тухай хуулийн 33.2 дугаар зүйлийг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан 2023 оны А/447 дугаар тушаалаар батлагдсан “Эмгэг судлалын шинжилгээ хийх журам”-ыг баримтлан ажиллана.

3.11.Шинжээч нь шинжилгээний дээжийг лабораториас гаргасан зааврын дагуу авч, холбогдох лабораторид илгээх бичгийн хамт хүргүүлэх ба уг бичигт хэний, аль эрхтэнээс хэзээ, хэдий хэмжээгээр дээж авсан, түүнд ямар төрлийн шинжилгээ хийхийг тэмдэглэж, үхлийн шалтгааныг товч бичнэ.

3.12.Цогцост илэрсэн гэмтэл, өөрчлөлт, лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн баримт бичиг, бусад материалыг нэгтгэн үнэлж үзсэний үндсэн дээр шинжээч эмч шүүх эмнэлгийн шинжилгээний онош тавина.

3.13.Тухайн хүний нас барсан шалтгааныг тогтоож, онош тавихдаа шинжээч эмч “Өвчний олон улсын ангилал”-ыг баримтална.

3.14.Цогцост шаардлагагүй зүслэг хийх, эд, эрхтнийг таслах, авахыг хориглоно.

3.15.Цогцсыг дүрслэл оношилгооны аргаар шинжилж болох бөгөөд цогцост хийх дүрслэл оношлогооны шинжилгээг дангаар болон цогцсын шинжилгээтэй хавсарч хийж болно.

3.16.Цогцост дүрслэл оношлогооны аргаар шинжилгээ хийсэн бол дүгнэлтийг цогцост шинжилгээ хийсэн дүгнэлтийн адил үнэлнэ.

3.17.Цогцост дүрслэл оношлогооны аргаар шинжилгээг хийхдээ “Рентген оношлогооны төхөөрөмжийн ажиллагаанд чанарын хяналтын хэмжилт хийх арга” Монгол Улсын стандарт MNS 5391:2010-г баримтална.

3.18.Нас барагчийн эцэг, эх, ах, дүү, төрөл төрөгсдөөс нь хүсэлт гаргасан тохиолдолд цогцост шүүх эмнэлэгийн шинжилгээ хийх ажиллагаанд байлцуулж болно.

Дөрөв. Хэргийн материалд шүүх эмнэлгийн шинжилгээ хийх

4.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу хэргийн материалд бүхэлд нь, эсхүл холбогдох хэсэгт шинжилгээ хийнэ.

4.2.Шинжилгээ хийх явцад шаардлагатай гэж үзвэл шинжээч томилсон шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэж мэргэжилтэн, шинжээчийг нэмэлтээр томилуулна.

4.3.Хэргийн материал нь дүгнэлт гаргахад шаардлага хангахгүй, эмнэлгийн баримт материал дутуу бол уг материалыг ирүүлсэн холбогдох шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд буцаах, эсхүл шаардлагатай баримт материалыг нэмэлтээр авч хугацааг сунгуулна.

4.4.Хэргийн материалд шинжээчийн дүгнэлт гаргахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүний биед үзлэг хийх, нэмэлт лабораторийн болон багажийн шинжилгээ хийх, цогцос болон оршуулсан цогцос шинжлэх зэрэг ажиллагаа хийж болох ба энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

4.5.Оршуулсан цогцос шинжлэх шаардлагатай тохиолдолд энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэж, уг ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

4.6.Хэргийн материалд хийсэн шинжилгээний дүгнэлт дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ:

4.6.1.удиртгал хэсэгт шинжилгээ явуулж эхэлсэн, дууссан он сар, өдөр, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн албан тушаал, овог, нэр, томилсон он сар, өдөр, дүгнэлт гаргаж байгаа шинжээчийн овог, нэр, боловсрол, мэргэжил, ажилласан жил, эрдмийн

зэрэг, цол, албан тушаал, шинжилгээний объектын талаарх мэдээлэл, тодорхой тохиолдолд овог, нэр, нас, хүйс, гэрийн хаяг, тухайн хэргийн болсон үйл явцын товч мэдээлэл, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс тавигдсан асуултууд;

4.6.2.үндэслэл хэсэгт хэргийн материалыг шинжилсэн явц буюу дүгнэлт гаргахад үндэслэл болгосон баримт материал /шинжээчийн дүгнэлт, эмнэлгийн баримт бичиг, шаардлагатай бол хэргийн газрын үзлэг, гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг г.м/-ын түүврийг хэргийн материалын хуудасны дугаар, он сар өдөр;

4.6.3.дүгнэлт хэсэгт шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавигдсан асуулт тус бүрт өгсөн хариулт, дүгнэлтийн шинжлэх ухааны үндэслэл, тайлбар.

4.7.Хэргийн материалд шинжээчийн дүгнэлт гаргахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүний биед үзлэг хийх, нэмэлт лабораторийн болон багажийн шинжилгээ хийх, цогцос шинжлэх зэрэг ажиллагаа хийж болох ба энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

4.8.Шинжилгээний байгууллагаас шинжилгээ хийх явцад тухайн хэрэг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зүйлийг олж тогтоосон бол энэ талаар шинжээч томилох эрх бүхий этгээдээс тавигдсан асуултанд тусгагдаагүй ч дүгнэлтэнд тусгана.

Тав.Бусад

5.1.Шинжилгээний объектод онош тодруулах зорилгоор илгээх бичгийн дагуу эмнэлзүйн лаборатори, хор судлал, биологи, бичил амь судлал, шүүх эд судлал, дүрс оношилгоо, молекул генетик болон бусад шаардлагатай нарийн шинжилгээ хийж болно.

5.2.Шинжээчийн дүгнэлтэд мэргэжлийн болон орчуулах боломжгүй гадаад нэр томъёог олон улсын нэршлээр хэрэглэж болно. Энэ тохиолдолд утгыг заавал эх хэлээр ойлгомжтой тайлбарлана.

5.3.Нэмэлт болон дахин шинжилгээ хийхдээ өмнө гаргасан дүгнэлтийн шинжилгээний объект ба шинжилсэн явцыг дурдаж, нэмж хийсэн ажиллагааны үр дүнг тусгана.

5.4.Шинжилгээнд тусгай болон төрөлжсөн мэргэшлийн шинжээч, нэмэлт гишүүнээр ажилласан тохиолдолд хөлсийг шинжээч томилсон байгууллага холбогдох журмыг үндэслэн олгоно.

5.5.Шүүх хуралдаанд шинжээчээр оролцсоны хөлсийг Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуульд заасны дагуу олгоно.

5.6.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАНИЛЦУУЛГА

Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9 дэх хэсэгт заасныг үндэслэн “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”-ын төслийг боловсруулав.

Эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад анагаах ухаан, биологийн холбогдолтой асуудлаар шүүх эмнэлгийн шинжилгээ хийх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор уг журмыг Шүүх шинжилгээний хуультай нийцүүлсэн гаргасан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хууль зүйн Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан 2014 оны А/215/421 дугаар тушаалаар батлагдсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”-д хүчингүй болсон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, мөн хэрэглэгдэхээ больсон “Мөрдөн байцаагч” гэсэн нэр томъёонууд байгаа учраас одоо мөрдөгдөж байгаа хуулийн нэр томъёогоор өөрчлөх шаардлага гарсан.

Уг журмын төсөлд шүүх эмнэлгийн шинжилгээний объект тус бүрээр шинжлэх үйл ажиллагааг Шүүх шинжилгээний хуулийн зүйл заалттай уялдуулсан ба Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Цогцост шинжилгээ хийх журам”-тай хамтатган боловсруулсан.

Мөн шүүх эмнэлгийн шинжилгээг багаар хийх онцлог, шинжилгээ хийхэд баримтлах стандарт, цогцост дүрслэл оношилгооны шинжилгээ хийх шинэ арга аргачлалын талаарх зохицуулалтыг тусгасан.

_____ оОо _____